



HIGH IMPACT COACHING | ХҮЧИРХЭГ КӨҮЧИНГ

Көүчинг нь 2023 оны манлайллын хамгийн чухал ур чадваруудын нэгээр тодорсон бөгөөд хүн төвтэй соёлтой байгууллагын удирдах түвшний ажилтнуудад зайлшгүй шаардлагтай ур чадвар гэж үздэг болсон.

Өндөр үр дүнтэй ажилладаг манлайлагчид көүчингийг багийн гишүүдээ чиглэл заавраар хангах, тэдний ур чадварыг хөгжүүлж, зорилгодоо хүрэхэд нь туслахад ашигладаг. Удирдлага болон дэмжлэгийг зөв хослуулсан көүчинг нь хүн бүхэнд хамгийн сайн үр дүнг авчирдаг.

Дэйл Карнегийн энэхүү хөтөлбөр нь ажилтан бүрийг хамгийн боломжит богино хугацаанд амжилтад хүрэхэд нь туслах, нуугдмал чадваруудыг нь олж илрүүлэх чадварыг танд олгоно. Харилцахад хүндрэлтэй гэж тооцогддог ажилтнууд ч хүртэл энэхүү көүчингийн аргуудад эерэгээр хандах болно.

Удирдалагын хувьд хамгийн үр бүтээлтэй цаг бол тухайн ажилтантай төлөвлөсөн болон санаандгүй тохиох ганцаарчилсан уулзалтууд юм. Энэ бол тухайн ажилтан танд бүх анхаарлаа төвлөрүүлж, илэн далангүй ярих боломжтой үе байдаг. Гэсэн хэдий ч олон удирдлагууд эдгээр яриаг көүчинг хийх боломж болгон хувиргах ур чадвар дутмаг учраас үр дүн муутай ярианд эдгээр үнэт мөчүүдийг дэмий үрдэг.

Энэхүү хөтөлбөрөөр мэргэжлийн түвшинд бусдыг чиглүүлж зөвлөх, сурган дадлагажуулах олон чухал арга барилыг эзэмшиж, бусдад хүлээн зөвшөөрөгдсөн манлайлагч болох ур чадвараа цогцоор нь хөгжүүлэх боломжтой.

Хэн оролцох вэ?

Дээд түвшний удирдах ажилтнууд, зөвлөх үйлчилгээ эрхэлдэг хүмүүс, багш, сурган хүмүүжүүлэгчид, байгууллагын сургалт хариуцсан ажилтан болон хүний нөөцийн мэргэжилтнүүд, захирлууд, энэ ур чадварыг судалж, хөгжүүлэхийг хүссэн хүн бүхэнд нээлттэй хөтөлбөр юм.

Сургалтын агуулга	Сургалтад оролцсоноор та дараах чадваруудыг эзэмшинэ
Көүчингийг талаарх ойлголтоо цэгцлэх нь	<ul style="list-style-type: none"> Көүчинг гэж юу болох мөн зорилгыг ойлгох нь Көүчингийн хэлбэр болон итгэл үнэмшлийн нөлөөг үнэлэх Көүчингийн өөрчлөлт болон бүтээмжтэй нэгтгэх
Идэвхтэй көүчинг хийхэд асуулт асуух, сонсох аргыг хэрэглэх	<ul style="list-style-type: none"> Көүчингийн туршлагаа нэмэгдүүлэхийн тулд сонсох Оролцоог нэмэгдүүлэхийн тулд асуулт асуух чадвараа Саналаа хэлэх чадвараар найдвартай, итгэл даахуйц
Көүчинг ба сэдэлжүүлэлт	<ul style="list-style-type: none"> Хувь хүний сэдэлжих хүчин зүйлийг таних нь Ажилтан юуг хамгийн ихээр хүсдэг талаар дүгнэлт хийх Багийн гишүүнийг амжилтад хүргэх нөөц боломжоор
Көүчингийн ур чадварыг хөгжүүлэх нь	<ul style="list-style-type: none"> Көүчингийн үйл явцыг ойлгох Көүчингийн стратегийг тодорхойлох Көүчингийн арга техникийг турших
Бүтээмж сайжруулахад чиглэсэн көүчинг	<ul style="list-style-type: none"> Көүчингийн ур чадвараа туршилт, хариу сэтгэгдлээр Көүчингийн олон төрлийн аргад суралцах Көүчингийн үйл явцыг үнэлэх
Эерэг хариулт өгч сайшаан дэмжих	<ul style="list-style-type: none"> Сайжруулах боломж болон өсөлтийг үнэлэх Тасалдсан гүйцэтгэлтэй тулж ажиллах тоглоомын дүрэм Хариуцлагатай байдлыг төлөвшүүлэхэд чиглэсэн алхмаар